



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 8/147

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "д", 29.2, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн төвийн дулаан хангамжийн системд тохируулга, зүгшрүүлэлт, тооцоо судалгаа хийх "Орон нутгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл, шугам сүлжээний ажлын хэсэг"-тэй хамтран ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга хот байгуулалт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Мэргэжлийн хяналтын газрын дарга

"Ган-Илч" ХХК-ний захирал

"Дундговь-Ус" ОНӨҮГазрын дарга

"Тэвшийн говь" ХХК-ний захирал

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ний орон нутгийн дулаан хангамжийн хэсгийн судалгаа тооцооны инженер

"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ний орон нутгийн дулаан хангамжийн хэсгийн тохируулгын ажилтан

Хоёр. "Орон нутгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл, шугам сүлжээний ажлын хэсэг"-тэй хамтран дулаан хангамжийн системд тохируулга, зүгшрүүлэлт, тооцоо судалгаа, мэдээ, мэдээллээр хангах, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга/-т даалгасугай.

Гурав. Дулаан хангамжийн системд тохируулга, зүгшрүүлэлт, тооцоолол хийсэн мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүн /"Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ний орон нутгийн дулаан хангамжийн хэсгийн судалгаа тооцооны инженер, тохируулгын ажилтан нар/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

023000422